



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2022/176/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2022 он

Дарга,

тэргүүлэх аудитор:

М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: [narantuyam@audit.gov.mn](mailto:narantuyam@audit.gov.mn)

Аудитын менежер:

Г.Даваа

Утас: 99035990 Цахим хаяг: [davaag@audit.gov.mn](mailto:davaag@audit.gov.mn)

Ахлах аудитор:

С.Ариунбаяр

Утас: 99076224 Цахим хаяг: [ariunbayars@audit.gov.mn](mailto:ariunbayars@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.8.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	10
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
4. Аудитын илрүүлэлт .....	11
4.1 Залруулсан алдаа .....	11
4.2 Зөвлөмж.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НББ	Нягтлан бодох бүртгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518398, Факс: 70518398  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠑᠙᠙᠘.᠐᠔.᠒᠙ № ᠒᠔᠔.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Д.ГЭРЭЛБАДРАХ ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,250,856,670.0</u>	<u>959,053,512.0</u>
33	АВЛАГА	1,250,856,670.0	959,053,512.0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	7,654,250.0	12,486,700.0
335	Бусад авлага	1,243,202,420.0	946,566,812.0
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,243,202,420.0	946,566,812.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,250,856,670.0</u>	<u>959,053,512.0</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>41,341,400.0</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	41,341,400.0	-
413	Өглөг	41,341,400.0	-
4136	Бусад өглөг	41,341,400.0	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,209,515,270.0</u>	<u>959,053,512.0</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,209,515,270.0	959,053,512.0
512	Хуримтлагдсан үр дүн	1,209,515,270.0	959,053,512.0
51210	Өмнөх үеийн үр дүн	1,209,515,270.0	1,226,861,020.0
51220	Тайлант үеийн үр дүн	-	(267,807,508.0)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,250,856,670.00</u>	<u>959,053,512.00</u>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	531,247,812.0	663,547,826.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,518,812.0	81,355,226.0
120	Нийтлэг татварын бус орлого	44,518,812.0	81,355,226.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,518,812.0	81,355,226.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,518,812.0	81,355,226.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	486,729,000.0	582,192,600.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	301,588,500.0	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	301,588,500.0	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	185,140,500.0	582,192,600.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,140,500.0	28,935,350.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,650,250.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	173,000,000.0	542,607,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	555,893,062.0	931,355,334.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	555,893,062.0	931,355,334.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,588,500.0	29,635,600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,000.0	2,850,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.0	2,850,000.0

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	588,500.0	26,785,600.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	26,785,600.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	588,500.0	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	554,304,562.0	901,719,734.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	231,834,106.5	226,307,117.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	231,834,106.5	226,307,117.1
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,518,812.0	81,355,226.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,518,812.0	81,355,226.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,704,793.5	12,800,000.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,704,793.5	12,800,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	260,246,850.0	581,257,390.9
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	260,246,850.0	581,257,390.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(24,645,250.0)	(267,807,508.0)

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	1,209,515,270.00	1,209,515,270.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	1,209,515,270.00	1,209,515,270.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
C07	Тайлант үеийн үр дүн			0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	1,209,515,270.00	1,209,515,270.00
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	1,209,515,270.00	1,209,515,270.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	17,345,750.00	17,345,750.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	1,226,861,020.00	1,226,861,020.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	-267,807,508.00	-267,807,508.00
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	959,053,512.00	959,053,512.00

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>799,148,912.0</u>	<u>663,547,826.0</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	312,419,912.0	81,355,226.0
120	Нийтлэг татварын бус орлого	312,419,912.0	81,355,226.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	312,419,912.0	81,355,226.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	267,901,100.0	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,518,812.0	81,355,226.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	486,729,000.0	582,192,600.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	301,588,500.0	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	301,588,500.0	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	185,140,500.0	582,192,600.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,140,500.0	28,935,350.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,650,250.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	173,000,000.0	542,607,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>799,148,912.0</u>	<u>1,224,183,434.0</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	799,148,912.0	1,224,183,434.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,588,500.0	29,635,600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,000.0	2,850,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.0	2,850,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	588,500.0	26,785,600.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	26,785,600.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	588,500.0	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	797,560,412.0	1,194,547,834.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	471,992,706.5	506,648,517.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	471,992,706.5	506,648,517.1
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	45,519,172.0	93,841,926.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,519,172.0	93,841,926.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,801,683.5	12,800,000.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,801,683.5	12,800,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	260,246,850.0	581,257,390.9
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	260,246,850.0	581,257,390.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>=====</u> -	<u>(560,635,608.0)</u>
14	Бусад эх үүсвэр	-	560,635,608.0
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-	560,635,608.0
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<u>=====</u> -	<u>560,635,608.0</u>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	585,060,750.0	536,284,117.1	48,776,632.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	585,060,750.0	536,284,117.1	48,776,632.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,133,750.0	29,635,600.0	14,498,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,585,600.0	26,785,600.0	12,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,785,600.0	26,785,600.0	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,800,000.0	-	12,800,000.00
212	ТАТААС	-	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	540,927,000.0	506,648,517.1	34,278,482.90
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг			-
2132	Бусад урсгал шилжүүлэг	540,927,000.0	506,648,517.1	34,278,482.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	540,927,000.0	506,648,517.1	34,278,482.90
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт			-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	585,060,750.0	582,192,600.0	2,868,150.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	585,060,750.0	582,192,600.0	2,868,150.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	28,935,350.0	28,935,350.0	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,650,250.0	10,650,250.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	545,475,150.0	542,607,000.0	2,868,150.00

### **3. Аудитын тайлан**

---

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Ариунбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 1/57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын зорилго оршино.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь мэргэжлийн Засгийн газрын бодлого, шийдвэр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд "Өрх бүрд ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, ажилгүйдлийн түвшинг бууруулах, мэргэжлийн боловсрол олгох, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтод бүлгийн өрх иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 931,355.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9313.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,519.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 291,803.2 мянган төгрөгөөр буюу 23.3 хувиар буурсан бөгөөд энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээлийн эргэн төлөлттэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	1,250,856.7	959,053.5	(291,803.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,250,856.7</b>	<b>959,053.5</b>	<b>(291,803.2)</b>
Өр төлбөр	41,341.4		(41,341.4)
Засгийн газрын хувь оролцоо	1,209,515.3	959,053.5	(250,461.8)
Хуримтлагдсан үр дүн	1,209,515.3	959,053.5	(250,461.8)
Тайлант үеийн үр дүн	-	(267,807.5)	(267,807.5)
<b>Өр төлбөр, цэвэр өмчийн дүн</b>	<b>1,250,856.7</b>	<b>959,053.5</b>	<b>(291,803.2)</b>

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 545,475.1 мянга төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 542,607.0 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ. Төсвийн гүйцэтгэлийг 521,498.5 мянган төгрөгөөр илэрхийлж төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 21,108.5 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн дансанд төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлээр гарсан нийт зардлын 296,000.0 мянган төгрөг буюу 56.7 хувийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл эзэлж байгаа бол 225,498.5 мянган төгрөг буюу 43.3 хувийг нийтийг хамарсан ажил, ажлын чиг баримжаа олгох сургалт, хяналт шалгалтын албан томилолт, шатахуун зэрэг зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нэмэлт санхүүжилтийн дансаар 39,585.6 мянган төгрөг төвлөрч, 26,785.6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 12,800.0 мянган төгрөгийг санхүүжүүлэгч байгууллагын дансанд төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансаар гарсан хөрөнгийн эх үүсвэрийг авч үзвэл:

- *Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг хийхэд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 10,650.2 мянга, Швейцарын хөгжлийн агентлагийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн санхүүжилтээр 16,135.4 мянган төгрөгийг олгожээ;*
- *Дэлхийн банкны хөдөлмөрийн зах зээлийн туршилтын санхүүжилтээр 12,800.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн боловч тайлант онд тус хөтөлбөр хэрэгжээгүйгээс тухайн байгууллагын дансанд төвлөрүүлсэн байна.*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сантай холбоотой байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилт 88.5 хувьтай байна.

Тайлант онд 71 иргэнд ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байр дэмжих зорилгоор 296,000.0 мянган төгрөгийн эргэн төлөгдөх зээл олгосон бөгөөд санхүүгийн тайланд иргэн тус бүрээр авлага үүсгэж бүртгэсэн байна.

Өмнөх онуудад иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн гэрээний хугацаа дууссан, эргэн төлөлтийг хуваарийн дагуу гүйцэтгээгүй зэрэг 29 иргэний 146,550.0 мянган төгрөгийн зээлийг шүүхэд шилжүүлснээс 5 иргэний 21,910.0 мянган төгрөгийн зээлийг шийдвэрлэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих мэдээллийн бүрэн мэдээлснээс 115 мэдээллийг хуулийн хугацаанд, 22 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Зарим мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 210,049.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, 200,000.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, дотоод хяналттай холбоотой 1 зөвлөмж хүргүүлж, шийдвэрийн биелэлтийг 2021 оны 1/132 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзвэл:

- Төлбөрийн актаас 146,072.0 төгрөгийн хэрэгжилтийг ирүүлж, хэрэгжилт 60.9 хувьтай;
- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой 200,000.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсний хэрэгжилтийг бүрэн тайлагнасан байна.
- Дотоод хяналттай үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж хүргүүлснээс дотоод хяналтын төлөвлөгөөг гаргаж хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 86.6 хувьтай байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар олгогдсон зээлийн төсөл хөтөлбөр, ажил чиг баримжаа олгох сургалтын сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэйгээр явуулдаг эсэх талаар “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитаар нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 42,627.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,052.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 40,575.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

### 4.1 Төлбөрийн акт

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- *Ажлын байр дэмжих хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан зарим иргэн гэрээний үүргийг хэрэгжүүлээгүйгээс 2,052.5 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг хугацаа хэтрүүлсэн байна.*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3<sup>1</sup>, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 1 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтын 4.1, 5.1.3<sup>2</sup>, хамтран ажиллах гэрээний 3.5<sup>3</sup>, 3.6<sup>4</sup>, 3.7<sup>5</sup> холбогдох заалтуудыг зөрчсөн байна;

<sup>1</sup> .төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

<sup>2</sup> Санхүүгийн дэмжлэгийг ....36 сарын дотор хуваарийн дагуу 100 хувь эргүүлэн өнгөн хэлбэрээр төлнө.

<sup>3</sup> Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан “Эргэн төлөлт хийх төлөвлөгөө”-ний дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлнө. Санхүүгийн дэмжлэгийн зардлын төсвийн тооцоог гэрээний хавсралтаар гаргана.

<sup>4</sup> Санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь тогтоогдсон, эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлж барагдуулаагүй хугацаа хэтрүүлсэн тохиолдолд санхүүгийн дэмжлэгийн нийт хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлж барагдуулна.

## **4.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

*Томилолтоор ажилласан албан хаагчдад 11,431.0 мянган төгрөгийг олгосон боловч тушаал шийдвэр гаргаагүй, зарим албан хаагчид томилолтоор ажилласан илтгэх хуудас бичээгүй, томилолтын хуудсыг даргаар хаалгаагүй байна.*

#### Өгсөн зөвлөмж:

Албан томилолтоор ажиллуулахдаа даргын тушаал гаргаж, илтгэх хуудсыг бичиж, томилолтыг хаалган баталгаажуулж, төсвийн хөрөнгийг үр ашигтайгаар захиран зарцуулах;

### **2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан 10,670.8 мянган төгрөгийн шатах тослох материалын зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсаар үнэн зөв, бүрэн гүйцэт гаргаж тайлагнаагүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтын дагуу иж бүрэн, үнэн зөв хөтөлж, тооцоог бодож, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.5-д холбогдох албан тушаалтнууд гарын үсэг зурж, баталгаажуулах;

### **3. Төсөл хөтөлбөртэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Ажлын байр дэмжих хөтөлбөрийн хүрээнд 14,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон төслийг авч үзэхэд төслийн тооцоо судалгаа нь бодитой боловсрогдоогүй, хэрэгжих нь тодорхойгүй байхад сонгон шалгаруулсан байна.

#### Өгсөн зөвлөмж:

Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг, төсөл бүрийг нягтлан тооцоо судалгааг бодитой үнэлэх, хэрэгжих нь тодорхойгүй төслийг сонгон шалгаруулахгүй байх, мөн дотоод хяналт төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад хяналтыг хэрэгжүүлж, төсөл, хөтөлбөрийн үр ашгийг дээшлүүлэх;

### **4. Авлагын данстай холбоотой**

#### Илрүүлэлт:

*Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн малжуулах хөтөлбөрт 2014 онд хамрагдсан Баяндэлгэр сумын 2 иргэн байгалийн давагдашгүй хүчин зүйл /зуд/ болон ар гэрийн гачигдлын улмаас малгүй болж 3,973.2 мянга, 2015 онд төсөлд хамрагдсан Халзан*

сумын 1 иргэн малгүй болсны улмаас 500.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх боломжгүй найдваргүй авлага үүссэн байна.

**Өгсөн зөвлөмж:**

Санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх боломжгүй болсон дээрх иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХЭДС	5	42,627.5			1	2,052.5			4	40,575.0
	ДҮН	5	42,627.5			1	2,052.5			4	40,575.0